

**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2013 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

2013.11.25

Ховд

Д/д	Зорилт	Биелэлт	Хувь
Нэг. Төрийн удирдлага, эрх зүйн бодлогын хүрээнд:			
1.1. Төрийн байгуулалтын талаар:			
1.1.1	Аймгийн төр захиргааны байгууллагын бүтэц, орон тоо бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоож мөрдөнө.	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог хэлэлцэж, удирдах бүрэлдэхүүн 4, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс 7, Хяналт-шинжилгээ үнэлгээний тасаг 3, Санхүү, төрийн сангийн хэлтэс 9, Нийгмийн хөгжлийн хэлтэс 5, Хөгжлийн бодлогын хэлтэс 6, Хууль зүйн хэлтэс 5, Цэргийн штаб 2 нийт 41 орон тоотой байхаар урьдчилсан байдлаар тогтсон.	90
1.1.2	Төрийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй шударга үйлчилдэг нийтийн алба болгоно.	Төрийн албыг нийтийн алба болгох хуулийн хэлэлцүүлэг, Төрийн албаны шинэчлэл-мерит тогтолцоо сургалт зохион байгуулав. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн С.Хадхүүгээр ахлуулсан ажлын хэсэг аймгийн нийт төрийн албан хаагчидтай уулзалт хийж, ярилцлага зохион байгууллаа.	70
1.1.3	Төрийн байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага, шалгуурыг өндөржүүлнэ.	Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журмын дагуу зөвлөгөө өгч, гэрээ байгууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2013 оны А/25 дугаар тушаалаар ажлын байрны тодорхойлолтыг дахин боловсруулалт, хянан баталгаажуулалт хийж, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлав.	90
1.1.4	Боловсон хүчнийг судлах, өөрийн болон гадаад орнуудад сургаж дадлагажуулах, давтан сургах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж мөрдөнө.	Боловсон хүчнийг сургаж дадлагажуулах чиглэлээр Удирдлагын академид Засгийн газрын захиалгаар аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, хүний нөөцийн болон сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн, хэвлэл мэдээллийн ажилтныг сургалтад хамрууллаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан зөвлөлгөөнд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, манай аймагт зохион байгуулагдсан Мэргэжлийн хяналтын газар, Нийтлэг үйлчилгээний албаны бүсийн сургалт, Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан Хяналт-шинжилгээ үнэлгээний болон архив, бичиг хэргийн ажилтнуудын сургалтанд холбогдох мэргэжилтнүүд оролцов. Удирдлагын академид Засгийн газрын тэтгэлгээр 3, төлбөртэй 6, магистрын сургалтанд 1 нийт 10 хүн элсэн суралцаж байна.	90
1.1.5	Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнд 1/3-аас доошгүй иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулна.	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын журмыг шинэчлэн 11 гишүүнтэй байсан зөвлөлийг 15 гишүүнтэй болгож, Ахмадын хорооны дарга, Үйлвдэрчний эвлэлүүдийн холбооны дарга, Залуучуудын холбооны тэргүүн нарын төлөөллийг орууллаа.	90
1.1.6	Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг иргэдийн дунд нээлттэй хийж, төрийн байгууллагуудаас “Иргэдийн өдөр” зохион байгуулна.	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын мэдээллийг аймгийн вэб сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлж байна. Сум, албан байгууллагуудын “Иргэдийн өдөр” зохион байгуулах хуваарь гаргаж 42 сум, байгууллага давхардсан тоогоор 58 удаа “Иргэдийн өдөр” зохион байгууллаа.	100
1.1.7	Аймгийн иргэний	Аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтарч иргэний танхим	90

	танхимыг байнгын ажиллагаатай болгоно. Сумдад иргэний танхим ажиллуулж тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг иргэдээрээ хэлэлцүүлэн шийдвэрлэдэг болно.	байгуулсан. Сумдын ЗДТГ-т иргэний танхим байгуулж, ажиллах журмыг баталлаа. Аймгийн иргэний танхимаар “Иргэдийн оролцоо-иргэний танхим”, “Иргэний танхимын ажиллах журам”, “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай” хууль сурталчлах зэрэг томоохон хэлэлцүүлэг зохион байгуулсан. Аймгийн иргэний танхимыг хариуцсан 2 мэргэжилтэн ажиллаж байна.	
1.1.8	“Цахим засаглал” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	“Цахим засаглал” хөтөлбөрийг боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвийг шинээр нээж ажиллуулсан нэг сарын хугацаанд 59 хэрэглэгч хандаж, санал гомдол ирүүлснийг холбогдох газарт нь уламжилжээ. Аймгийн албан ёсны www.khovd.gov.mn вэб сайтыг байнгын ажиллагаатай болгож, мэдээллийг тухай бүр баяжуулж, нэг жилийн хугацаанд давхардсан тоогоор 20 000 гаруй хэрэглэгч хандсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Ногоон Ховд зэрэг фэйсбүүк хуудас ажиллуулж байна.	100
1.1.9	Сум, баг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх тухай журмыг шинээр боловсруулж мөрдөнө.	Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Сумдын Засаг даргын Тамгын газар, төсвийн байгууллагууд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг боловсруулан хэлтэс, тасгуудаас санал авч нэгтгэн, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.	90
1.1.10	Уламжлалт харилцаатай орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, оюутан сургах, солилцох ажиллагааг өргөжүүлнэ.	ОХУ-ын Алтайн хязгаарт Засаг даргын айлчлал хийж худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд 600 гаруй тн төмсийг ОХУ-д экспортолж, Алтайн хязгаараас өндөр үр ашигтай, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхийн тулд сайн үүлдрийн бод мал худалдаж авах анхны хэлэлцээр хийсэн. БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай, Цонж аймгууд, Чингэл сумын удирдлагуудтай удаа дараа боомтын ажлын цагийг уртасгах, татвар хураамж өндөр байгаа талаар асуудал тавьж хэлэлцээр хийсний үндсэн дээр энэ сараас эхлэн зорчигч тээврийн автобус явуулахад бэлэн болоод байна. 2013-2014 оны хичээлийн жилд БНХалимаг улсын Их сургуулийн бэлтгэл ангид 5 оюутан өөрийн зардлаар, Алтайн Хязгаарын барилга, цэцэрлэгийн багш, хөдөө аж ахуйн коллежуудад 10 оюутан, Япон, ОХУ, Швед зэрэг оронд Ховд их сургуулийн багш нар мэргэжил дээшлүүлж аспирантур, докторантурт суралцаж байна. АНУ, Солонгос, Япон улсад технологи, тоног төхөөрөмж, бизнес санаа олох, бизнесийн түнш, хөрөнгө оруулагч татах эхний аяллыг амжилттай зохион байгууллаа. Монгол, ОХУ, БНХАУ, БНКаЗулсууд оролцсон “Их Алтай” спорт-аялал жуулчлалын олон улсын их наадмыг анх удаа амжилттай зохион байгуулж, 200 гаруй тамирчин, 2000 гаруй сонирхогч оролцов. ОХУ-ын Алтайн хязгаарт зохион байгуулсан “Хөх шувуухай” олон улсын наадамд хүүхдийн урлагийн хамтлаг амжилттай оролцож “Шилдэг хамтлаг”-ийн эзэд болов. ШУӨЗО-ны нийслэл Үрэмч хотод болсон “Китай экспо-2013”, Алтайн БНУлсын Кош-Агачийн районд болсон олон улсын анхдугаар үзэсгэлэн худалдаанд бизнес эрхлэгчдийг зохион байгуулан оролцуулж, 50 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж, цэвэр арьс, ширээр хийсэн “Цасны хаан”-ны дулаан гутал ихээхэн эрэлт хэрэгцээтэй байлаа.	100

1.1.11	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн зарим барилга байгууламжийг шинээр барих, сэргээн тохижуулах ажлыг эхлүүлнэ.	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн актлагдсан соёлын төвийн хуучин барилгыг буулгаж газрыг бэлтгэсэн. 2014 онд хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх болсон.	50
1.2. Эрх зүйн бодлогын талаар			
1.2.1	Аюулгүй байдлыг хангах болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, терроризмтэй тэмцэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулна.	Зөвлөлүүдийг шинэчлэн зохион байгуулж 2-3 удаа хуралдуулж холбогдох асуудлуудыг шийдвэрлэсэн.	100
1.2.2	Аймгийн төвийн нутагт хүн ам ихээр төвлөрсөн, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдийг телекамерын системд холбох замаар иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах ажилд орчин үеийн техник хэрэгслийг нэвтрүүлнэ.	Жаргалант сумын нутаг дэвсгэрт хүн, ам төвлөрсөн, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдэд хяналтын камерийг байрлуулах талаар холбогдох бичиг баримтыг бүрдүүлж шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлүүлээд байна.	50
1.2.3	Сумдад ажиллаж байгаа цагдаагийн нэгжүүдийг орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмж, уналгын хэрэгслээр үе шаттайгаар хангах замаар иргэдэд хүрч үйлчлэх үйлчилгээг хүртээмжтэй болгох судалгааг хийж, дараагийн жилд хийх ажлын бэлтгэл хангана.	Сумдын хэсгийн төлөөлөгч цагдаа нарт шаардлагатай байгаа 16 тээврийн хэрэгсэл, “Canon” маркийн дижитал аппарат нийт төсөв 164.160.000 төгрөгний үнийн саналыг зах зээлийн ханшинд тулгуурлан холбогдох судалгааг гаргаж 2013 оны нэгдүгээр улиралд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулан, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж аймаг, сумын төсөв, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөс шат дараатайгаар шийдвэрлэхээр болсон. Хэсгийн төлөөлөгч цагдаа нарыг холбоо мэдээллийн сүлжээнд холбох талаар орон нутгийн хөгжлийн санд тусган хэрэгжүүлэх байсан ч хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахыг хориглосон учраас энэ ажил биелэгдээгүй боловч ХААН банкны онлайн сүлжээг ашиглан холбоо мэдээллийн шуурхай байдлыг ханган ажиллаж байна.	90
1.2.4	Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх иргэдийн амар тайван байдлыг сахин хамгаалах ажилд дэмжлэг үзүүлж ажиллана.	Нийт сумдын “Иргэний зөвлөл”-ийн гишүүдэд олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг 1 удаа, үйл ажиллагааны явцыг орон нутгийн Эко телевиз, улмаар TV-9 телевизээр мэдээлсэн. “Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах нь” сэдэвт сургалтыг Архидалт мансуурлын эсрэг ассоциаци, аймгийн ГХУСАЗЗ-тэй хамтран зохион явуулж аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, ЕБС-ийн удирдлага, нийгмийн ажилтан, цэцэрлэгүүдийн эрхлэгч, Цагдаа, Шүүх, Прокурор зэрэг 13 төрийн байгууллагын 116 ажилтан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 52, ЗХ-ний 123 дугаар ангийн 85, Дотоодын цэргийн 17, ЕБС-ийн ахлах ангийн 500, баривчлагдсан 17 хүнд тус тус сургалт явуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа. “Архигүй Монголын төлөө хамтдаа” уриалгыг дэмжих, архины хор уршгийг хүүхэд залуучуудад багаас нь ойлгуулж, түүнийг жигших үзлийг төрүүлэх, архины хамааралтай хүмүүсийг нийгэмшүүлэх, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өндөржүүлэх ажилд	100

		хэвлэл мэдээллийн байгууллагыг өргөнөөр татан оролцуулах зорилгоор аймгийн ГХУСАЗЗ-тэй хамтран "Гэр бүлийн хүчирхийлэл, архины хор хөнөөл" сэдэвт зорилтот нэвтрүүлэг, нийтлэл, шторкийн уралдааныг аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын дунд зарлан шалгарууллаа.	
1.2.5	Архи, тамхигүй-Ховд хүн дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх замаар архи тамхигүй орчныг бүрдүүлж, согтууруулах ундаа хэрэглэдэггүй эрүүл идэвхтэй амьдралын клубыг сумдад байгуулахыг дэмжиж, төсвийн мөнгөөр архи согтууруулах ундаа худалдан авахыг таслан зогсооно.	Хөтөлбөрийн төсөл бэлтгэгдсэн. Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэлэлцүүлгийг төрийн байгууллага албан хаагчдыг оролцуулан хийж төсвийн байгууллагуудын дотоод журамд тамхигүй орчин бүрдүүлэхтэй холбоотой заалт оруулсан эсэхэд хяналт хийж, хуулийн хэрэгжилтийг бүх байгууллагад шалган төсвийн мөнгөөр архи согтууруулах ундаа авахыг хориглосон заалт бүхий аймгийн Засаг даргын албан даалгавар хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллалаа.	70
1.2.6	Хил хамгаалах сайн дурын туслах хүчний үйл ажиллагааг тогтворжуулж, залуучуудын эх оронч сэтгэлгээг төлөвшүүлнэ.	Хилийн бүсийн сумдад үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын удирдагчдын зөвлөгөөн, аймгийн Засаг даргын дэргэдэх Хил хамгаалахад туслах хүчний орон тооны бус Зөвлөлийн хурлыг тус тус хийж хил хамгаалахад чиглэсэн ажлын үр дүнгээ хэлэлцэн цаашдын бодлого зорилтоо тодорхойлон ажиллав. Мөн хил орчмын бүсэд оршин суугчдын цугларалтуудыг хэсэгчлэн хийж, ХХТХ-ний гишүүдтэй гэрээ байгуулан холбогдох хууль дүрэм заавраар сургалтууд хийж хил хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог ханган ажилласан байна. Сум орон нутгийн өсвөр залуу үеийнхэнд эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилготой сурталчилгаа мэдээлэл хийж, хил хамгаалахтай холбогдох түүхэн газар, хөшөө дурсгалуудыг сэргээн засварлаж хүндэтгэл үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд залуу үеийнхнийг татан оролцууллаа.	100
1.2.7	Аймаг сумдын иргэний танхим, эрхзүйн сургалт сурталчилгааны танхимаар дамжуулан шинээр батлагдан гарсан эрхзүйн актуудын мэдээллийг иргэдэд тогтмол хүргэж хэвшинэ.	Аймгийн хэмжээнд хийгдэх "Эрх зүйн сургалт сурталчилгаа мэдээллийн нэгдсэн хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохицуулан зохион байгуулж байна. Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран "Хууль дүрэм бодит амьдралд" аяныг 6 сумыг хамруулан 6 сарын хугацаатай зохион байгуулж, үр дүнгийн хэлэлцүүлгийг бүх сумын төлөөллийг оролцуулан хийж, аяны сайн туршлагыг нэгтгэн сумдад хүргүүлж, аяны хүрээнд хийгдсэн сургалт сурталчилгаа мэдээллийг 18000 гаруй иргэнд хүргэсэн ба аяныг цаашид дахин үргэлжлүүлэхээр тохиролцоод байна. Сумдын Засаг даргын Тамгын газраар дамжуулан иргэдэд хүргэх эрх зүйн мэдээллийн гарын авлага, тараах материал нийт 1500 ш-ийг түгээлээ. 2, 4 дүгээр улиралд "Таны хуулийн хөтөч", "Эрх зүйн мэдээллийг иргэн бүрт" сэдэвт аянуудыг зохион байгуулж иргэдэд эрх зүйн мэдээлэл түгээх ажлууд хийгдлээ.	100
1.2.8	Хүүхэд залуучуудын хүмүүжилд сөргөөр нөлөөлж буй нөхцөл, үйл ажиллагааг хязгаарлан, өсвөр үеийнхэнд эх оронч, монгол ёс заншлаа дээдлэх үзлийг	Хүүхэд, залуучууд, өсвөр үеийнхнийг архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх зорилгоор "Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах нь" сургалтыг Улаанбаатар хотын архидалт мансуурлын эсрэг ассоциаци, аймгийн ГХУСАЗЗ-тэй хамтран зохион явуулж ЕБС-ийн удирдлага, нийгмийн ажилтан, цэцэрлэгүүдийн эрхлэгч, ЕБС-ийн ахлах ангийн 500 сурагчийг хамруулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа.	90

	төлөвшүүлнэ.		
1.2.9	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.	Хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдох хэлэлцүүлгийг төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж, хуулийг хэрэгжүүлэх үүрэг чиглэл хүргүүлэн дүгнэж, хуулийн сургалт сурталчилгааг бүх байгууллагуудад хийсэн ба “Мерси Кор” олон улсын байгууллагаас зарласан төслийн уралдаанд шалгарсан төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор 3 сумын “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, бусад сумдад туршлага болгохоор шийдвэрлэсэн.	100
1.2.10	Шүүх, прокурор, Цагдаа, ШШГА-ыг хуулийн дагуу хараат бусаар үйл ажиллагаа явуулахад холбогдох байгууллагуудтай хамтран дэмжлэг туслалцаа үзүүлнэ.	Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг хараат бусаар явуулахад мэргэжлийн болон холбогдох дэмжлэг үзүүлж ажиллаж байна.	90
1.2.11	Хоёр суманд цагдаагийн кабон байгуулна.	Мөнххайрхан, Буянт суманд баригдах цагдаагийн кабоны байр бариулах тендер шалгаруулалт хийгдэж, цагдаагийн кабоныг ашиглалтад оруулсан.	100
Хоёр. Нийгмийн бодлогын хүрээнд:			
2.1. Боловсролын талаар:			
2.1.1	Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг сайжруулж, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	Аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хамран сургалтыг бодит болгох, 2-14 насны бүх хүүхдийг бүртгэлжүүлэх зорилгоор хүн амын тоо, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарь, хүчин чадал зэргийг харгалзан аймгийн сургууль, цэцэрлэгүүдийн хамран сургах тойргийг шинэчлэн тогтоолоо. Ерөнхий боловсролын 24 сургуулийн 679 бүлэгт 17869 хүүхэд суралцаж, суурь боловсролын хамран сургалт 2013-2014 оны хичээлийн жилд 92,4 хувь буюу өмнөх оныхоос 0,8 хувиар нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд 2012-2013 оны хичээлийн жилд төрийн өмчийн 28, хувийн өмчит 2, нийт 30 цэцэрлэг, Булган сумын 2 баг, Үенч, Зэрэг, Мянгад, Цэцэг сумын Хөшөөтийн уурхайд нийт 6 багийн цэцэрлэг байнгын ажиллаж байна. Хувилбарт сургалтаар дамжуулан аймгийн 17 сумын 91 багийн хүүхэд багачуудад СӨБ-ын үйлчилгээ үзүүлж, сургуулийн өмнөх боловсролд 6116 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 83,6 хувь буюу өмнөх оныхоос 0.8 хувиар буурч, цэцэрлэгийн өдрийн ангид 4514 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 63,8 хувь болж 2,4 хувиар өслөө.	100
2.1.2	Бүх түвшний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөртэй уялдуулан суралцагчийн хэрэгцээ, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн орон нутгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.	Аймгийн Засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/57 тоот захирамжаар байгуулсан 21 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг багш, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөл нийт 2500 иргэний дунд 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулан саналыг авч, Боловсролын салбарыг 2013-2016 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, “Ном”, “Авъяас”, “Аварга” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.	100
2.1.3	Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон ёс зүй, цалин, урамшуулал, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Багш” дэд хөтөлбөр	“Багшийн хөгжил” хөтөлбөрийн төслийг багш, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөл нийт 2400 иргэний дунд 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулан, саналыг тусгаж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2013 оны 74 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 жилээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

	боловсруулан хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн хөгжлийн сангаас 32100,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олголоо.	
2.1.4	Орон нутгийн нөөц боломжид тулгуурлан "Ном", "Авьяс" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Авьяс хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 жилээр гаргаж, нийт 17 зорилтыг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 24 сургуульд нийт 683 дугуйлан хичээллэж, давхардсан тоогоор 17739 сурагч хамрагдан, 658 багш, 55 иргэд, ардын авьяастнууд хичээл зааж, БШУЯ-аас 12960 цагийн хөлс буюу 54.0 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилан олгож, орон нутгийн хөгжлийн сангаас тус хөтөлбөрийн үйл ажиллагаанд 23118,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Ном хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 жилээр боловсруулан 13 зорилтыг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Иргэдийг хүүхдийн ном бүтээх бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулах, хүүхдэд зориулсан бүтээлийн сантай болгох зорилгоор ном зохиох уралдаан, "Ном миний хөгжлийн гарц" сэдэвт эссе бичлэгийн уралдаан, "Ухаан далай номоос эхтэй" сургалт сурталчилгааг зохион байгуулж, нийтдээ тус хөтөлбөрийн үйл ажиллагаанд орон нутгийн хөгжлийн сангаас 13150,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэв.	100
2.1.5	"Оюунлиг-Ховд" хөтөлбөрийг олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлж, зарим зүйл заалтыг мэргэжлийн болон төрийн бус байгууллагад шилжүүлнэ	Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүдийн дунд "Амны хөндийн эрүүл мэнд" 3 сарын аян хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 28 эмчийг сургалтанд хамруулж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн мөрдүүлж, "Оюунлаг-Ховд" хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн 24 сургуулийн шилдэг 100 хүүхдийг шалгаруулж, батламж, хичээлийн иж бүрэн хэрэглэгдэхүүн, компьютер, олон улсын Найрамдал зусланд амрах эрхийн бичгээр шагнав.	100
2.1.6	Үндэсний лаборатори сургуулийн үйл ажиллагааг бэхжүүлэн, сургалтын дэвшилтэт технологийг орон нутгийн онцлогтой уялдуулан нэвтрүүлнэ.	Лаборатори 1 дүгээр сургуулийн захирал, эрхлэгч, бага ангийн багш, нийт 15 багш шинэ технологи нэвтрүүлэх сургалтанд хамрагдсан. Баруун бүсийн "Явцын үнэлгээ" сэдэвт сургалт зохион байгуулж, нийт 125 бага ангийн багш оролцлоо.	100
2.1.7	Албан бус боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн иргэдэд амьдрах ухааны болон бага, суурь, бүрэн дунд боловсролыг олгох, гэгээрэл төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулна	2012-2013 онд албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 913 хүүхэд залуус хамрагдаж, бага боловсролд 400, суурь боловсролд 299, бүрэн дунд боловсролд 214 хүүхэд залуус хамрагдсанаас бага боловсролыг 281, суурь боловсролыг 93, бүрэн дунд боловсролыг 93 хүүхэд залуус эзэмшиж дараагийн шатны сургууль, МСҮТ-д элсэн суралцахаар боллоо. Насан туршийн боловсролын гэгээрэл төвүүдээр ерөнхий боловсролын сургуульд 53 суралцагчийг шилжин суралцуулж, суурь боловсролыг 93 суралцагч, бүрэн дунд боловсролыг 93 суралцагч төгссөн байна. Гэгээрэл төвүүдийг насан туршийн боловсролын төв нэгж болгон өөрчлөн зохион байгууллаа. Насанд хүрэгчдийн ерөнхий боловсролыг дээшлүүлэх сургалтад 326, амьдрах ухааны сургалтад нийт 246 хүүхэд залуус хамрагдлаа.	100
2.1.8	Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг	Боловсролын салбарыг 2013-2016 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, "Ном", "Авьяс", "Багшийн хөгжил" хөтөлбөрийн төслийг багш, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөл нийт 2400	100

	орон нутагт хөгжүүлэх, олон нийтийн оролцоонд суурилсан иргэдэд ээлтэй үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	иргэний дунд 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулан, саналыг тусгаж ажиллалаа. Төр иргэд хувийн хэвшлийн түншлэлийн салбар хороог шинэчлэн байгуулж, гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. 70431111 төвийг нээн 2 оператор ажиллуулж 7 сувгаар иргэдийн санал, гомдол хүлээн авах, www.khovd-1111.mn вэб сайтаар дамжуулан холбогдох албан байгууллагын дарга, эрхлэгч нарт мэдээлж, тухай бүр нь хариултыг өгөх ажлуудыг хийж байна	
2.1.9	Хүүхэд харах үйлчилгээг бий болгож, хувийн цэцэрлэг ажиллуулах санаачилгыг дэмжин СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	“Хүүхэд харах үйлчилгээ” нээлттэй хэлэлцүүлгийг 200 иргэдийн /цэцэрлэгийн эрхлэгч, багш, эцэг эх, иргэд/ дунд зохион байгуулж, саналыг нэгтгэн БШУЯ-нд хүргүүллээ. Энэ хичээлийн жилд “Жаргалант Энхж-Од” цэцэрлэгийг 1 бүлэг, 25 хүүхэдтэйгээр байгуулан 2013 онд 17715.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилж олгов. 2014 оноос “Нарны хаан хүүхдүүд”, “Ээж гэр” хувийн цэцэрлэгүүд нээгдэж үйл ажиллагаа явуулахаар бэлтгэлээ хангаад байна.	90
2.1.10	ЕБС-ийн төгсөгчдийг элсэлтийн шалгалтад бэлтгэх, зөвлөгөө өгөх төв байгуулна.	ЕБС-ийн сурагчдыг элсэлтийн шалгалтад чанартай бэлтгэх, зөвлөмж чиглэлийг сургууль бүрт хүргүүлж, Цаст-Алтай цогцолбор сургуульд “Багш” сонгон хичээллүүлж 6 сургуулийн 25 сурагч хамрагдав. ЭЕШ-ийн төстийн эмхэтгэл номыг татан авч, ЭЕШ-д оролцох хүүхэд залууст зөвлөгөө өгч, бүртгэж ажиллав.	100
2.1.11	Жаргалант сумын 1 дүгээр сурууль, Цаст-Алтай, Чандмань, Дөргөн, Үенч, Булган, сумдын сургуулиудын өргөтгөлийн барилгыг шинээр барина.	Жаргалант сумын I, Булган сумын I, Дөргөн, Чандмань сумын сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн барилгын угсралтын ажлын явц 30 хувьтай байна. Үенч, Цаст-Алтай цогцолбор сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн барилга 2014 оны төсвийн төсөлд тусгагдсан байна.	30
2.1.12	Жаргалант суманд 150, Мөст сумдад 100 хүүхдийн цэцэрлэг шинээр барина.	Мөст сумын цэцэрлэг, Жаргалант сумын 4-р цэцэрлэгийн барилга угсралтын ажил 30 хувьтай байна.	30
2.1.13	Мөст сумын сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барьж, Жаргалант сумын дотуур байрны барилгыг засварлана.	Мөст сумын сургуулийн дотуур байрны барилгын тендер зарлаж хяналтын төсөв, батлагдсан төсөв зөрөөтэй байгаа шалтгаанаар 2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдахаар батлав. Булган сумын I, Жаргалант сумдын сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барих саналыг ЭЗХЯ, БШУЯ-д хүргүүлэв.	10
2.1.14	ХоИС-д СӨБ-ын багш бэлтгэх ангийг нээж, ЕБС-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг өргөжүүлнэ.	ХоИС-д сургуулийн өмнөх боловсролын багшийн ангийг шинээр нээж, баклаварын 5 мэргэжлээр 175 оюутан, докторын шатны сургалтад 2 мэргэжлээр 6 суралцагч суралцаж байна. Боловсрол, шинжлэх ухааны яам, орон нутгийн төр захиргаа, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүйг түгээн дэлгэрүүлэх 33 төрлийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2621 багш, удирдах ажилтан, тогооч, нярав, дотуур байрны багш, ажилтныг хамрууллаа.	100
2.1.15	Бүс нутгийн хөгжлийн талаар эрдэм шинжилгээний суурь болон хавсарга судалгааны ажлыг өргөжүүлж, “Баруун Монголын түүх соёл, байгалийн нөхцөл, нөөц	“Баруун Монголын хил залгаа нутгийн ард түмний түүх соёл, байгалийн нөхцөл, нөөц” олон улсын эрдэм шинжилгээний хурал 11 дэх удаагаа амжилттай явагдлаа. Орос, Хятад, Японы их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас 38 эрдэмтэн судлаачид, Америк, Солонгос, Норвеги, Швейцарь орны шинжлэх ухаан боловсрол, хүмүүнлэгийн байгууллага, МУИС, МҮИС, СУИС зэрэг Монголын тэргүүлэх их дээд сургууль, Монгол улсын ШУА-ийн эрдэмтдийн 20 гаруй	100

	ашиглалт” олон улсын эрдэм шинэжилгээний хурал зохион байгуулна.	төлөөлөл, ХИС-ийн болон Эрдэнэт, Улаангом, Улиастай, Өлгий хотуудын эрдэмтэн багш, судлаачид оролцлоо. Баруун Монголын болон хил дамнасан Алтайн бүс нутгийн байгаль хамгаалал, ашиглалт, экологи, түүх, археологи, угсаатны соёл, хэл аялгуу судлалын болон орчин үеийн шинжлэх ухаан, бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудал, дэлхийн хэмжээний асуудлыг хөндсөн 200 гаруй илтгэлийг 2 нэгдсэн хуралдаан, 9 салбар хуралдаанд хэлэлцүүлж, судалгааг цогц, системтэй болгох нэгдсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, онлайн хэлбэрээр явуулах зэргээр зохион байгуулалтыг илүү боловсронгуй болгох, баруун болон төв Европ, Азийн энэ чиглэлээр судалгаа явуулдаг эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон чухал шийдвэр гаргалаа.	
2.1.16	Хөгжил политехник коллежийн сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн шинэчилж, түншлэлийг өргөжүүлнэ.	“Хөгжил” политехник коллежийн техник технологийн шинэчлэл хийж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх чиглэлээр Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран ажиллаж, баруун бүсийн мэргэжлийн боловсролын сургуулийн төслийн хүрээнд жимс жимсгэнэ, хүнсний ногоо, самар боловсруулан даршлагч үйлдвэрлэлийн технологийн ажилтан мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулж, үнэлгээ хийлгэх шатандаа байна. Энэ мэргэжлийн хүрээнд 100.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж суурилуулах байрыг бэлтгэж, мэргэжлийн 30 иргэнийг сургаж байна.	100
Соёлын чиглэлээр:			
2.1.17	Олон ястны соёл, урлагийн үнэт өвийг өвлүүлэх, хадгалах, хамгаалах, баяжуулан хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.	Аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2013 оны 04 сарын 17-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор аймгийн “Алтан өв” хөтөлбөрийг батлуулан “Өв соёлоороо гоёцгооё”, “Айтыс” наадам, 7 сумын соёлын өдрийг зохион байгууллаа.	100
2.1.18	Соёл, урлагийн ажилтнуудын мэргэжил, арга зүйг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	16 сум, сургуулийн номын санчдыг соёл урлагийн байгууллагын тайлангийн программын сургалтад хамруулж, вэйб лавлагаа, номын сангийн тайлан, автоматжуулалт, тооллого, бүрдүүлэлт, захиалгын талаарх мэдлэгийг эзэмшүүлж, хамт олонд түшиглэсэн соёлын биет бус өвийн бүртгэлийн сургалтад аймгийн 2 мэргэжилтэнг хамруулав.	90
2.1.19	Жаргалант суманд соёл, спортын цогцолбор, Үенч суманд урлаг спортын цогцолбор төв байгуулна.	Цогцолборын тендер зарлагдаж батлагдсан төсөв нь хяналтын төсөвт хүрээгүй тул ирэх оны төсөвт тусгуулахаар саналаа ССАЖЯ-нд хүргүүлэв	30
2.1.20	Өв соёлын хүрээлэнгийн үзмэрийг нэмэгдүүлж, ардын зан үйл, өв соёлын сургалтыг өргөжүүлэн, өв соёлоороо гоёцгооё наадмыг зохион байгуулна.	“Өв соёлын хүрээлэн”-гийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үзмэр худалдан авах зардалд аймгийн ИТХТ-ийн хурлаар 26.0 сая төгрөгийг батлуулж, үзмэр худалдан авах ажлыг зохион байгуулав. “Өв соёлоороо гоёцгооё” уралдаанд 12 сумын 14 уран үйлчийн 56 бүтээл шалгаран оролцлоо.	100
2.1.21	Аймаг, сумын орон нутгийг судлах музейн үзмэрийн тооллого хийж, түүх соёлын	13 сумын орон нутаг судлах танхимын 777 дэсийн 1769 үзмэр, аймгийн музейн 892 дэсийн 2977 ширхэг үзмэрийг тус тус тоон мэдээллийн цахим хэлбэрт шилжүүлж, өв соёлын мэдээллийн санг баяжууллаа.	100

	дурсгалт зүйлсийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, түүх, өв соёлын мэдээллийн санг баяжуулна.		
2.1.22	Номын сангуудын фондыг орчин үеийн шинжлэх ухаан, технологийн мэдээлэл, мэдлэг агуулсан номоор баяжуулан үйлчилгээг өргөжүүлнэ.	16 сумын номын санд соёл урлагийн байгууллагын тайлангийн программын сургалтыг зохион байгуулж, иж бүрэн DELL компьютер, Алтай, Мөст, Цэцэг, Дөргөн, Мянгад, Чандмань сумдад уншигчийн ширээ, сандал, Мөст, Дуут, Ховд, Буянт, Чандмань сумдад заалны сандлыг тус тус олгож, номын санг 400 шинэ номоор баяжуулав.	100
2.1.23	Манхан, Ховд сумын спорт цогцолборын барилгыг ашиглалтанд оруулна.	Манхан сумын спортын цогцолборын ажлыг “Жаргалант луу” ХХК гүйцэтгэгчээр шалгарч ажил 30 хувьтай, Ховд сумын спорт заалны барилгын ажил 70 хувьтай хийгдэж байна.	50
2.1.24	Спортын хамтлагуудын чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.	Байгууллагуудын спортын хамтлагуудын ажлыг дэмжих чадавхийг нь дээшлүүлж, ЗХ-ний 123 дугаар анги, Голомт банк, Хаан банк, спорт хамтлагуудтай чөлөөт тоглолт явуулах гэрээ байгуулан ажиллаж холбоодуудын үйл ажиллагаа, олон улсын болон улсын чанартай тэмцээнүүдийг зохион байгуулахад 13.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.	100
2.1.25	“Аваргууд” хөтөлбөр боловсруулан аймгийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл хийх орчин нөхцөлийг сайжруулна.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 128 дугаар тогтоолоор аймгийн “Аварга” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж тамирчдын бэлтгэл хийх орчин нөхцөлийг сайжруулав.	100
2.1.26	Биеийн тамир спортыг бүх нийтийн үйл хэрэг болгох хөдөлгөөн өрнүүлж, спортын өндөр амжилт гаргасан тамирчдыг урамшуулах журам боловсруулан хэрэгжүүлнэ.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 129 тогтоолоор спортын өндөр амжилт гаргасан тамирчдыг урамшуулах журам боловсруулан батлуулж, олон улсын уралдаан тэмцээнд оролцсон 6 тамирчдад 3.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.	100
2.2. Эрүүл мэндийн чиглэлээр:			
2.2.1	Бүсийн оношлогоо эмчилгээний төвд тархины цахилгаан бичлэгийн аппарат, урологийн болон бүдүүн гэдэсний дурангийн оношлогоог нэвтрүүлнэ.	БОЭТ-д дурангийн оношлогоогоор 883 хүн (уушигны дурангийн оношлогоо 25, бүдүүн гэдэсний дурангийн оношлогоо 35, ходоодны оношлогоо 823) оношлогдож урологийн аппарат байрны хүрэлцээгүйгээс суурилагдаагүй байна. Иргэдийн хэрэгцээ шаардлагад үндэслэн Бүсийн оношлогоо эмчилгээний төвд бөөрний диалез, маммограммын аппаратыг суурилуулан ажиллуулснаар Улаанбаатар хотод сард 2-3 удаа явж эмчилгээ, хяналтанд байнгын эмчлүүлдэг 12 иргэн орон нутагтаа эмнэлгийн тусламж авах боломж бүрдлээ.	90
2.2.2	“Цахим эмнэлэг” хөтөлбөр боловсруулж, оношлогоо, шинжилгээ хийлгэх захиалга, лавлагаа, зөвлөгөөг цахим хэлбэрээр иргэдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Цахим эмнэлэг хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсөл хөтөлбөрийн арга хэмжээний зардлаас 40.0 сая төгрөгийг шийдвэрлэн серверийн болон хэрэглээний 20 ш компьютер, дарааллын дугаар олгох машин суулгаж, урьдчилан цаг авч бүртгүүлэх, утсаар мэдээлэх, хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчдийн хүлээлт, чирэгдлийг бууруулахад тодорхой дэвшил гарлаа. БОЭТ-ийн үйл ажиллагааны хүлээлтийн байдалд судалгаа хийж ачаалалтай байгаа тасгуудын үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор Зүрх судас, гэмтлийн тасгуудыг шинээр байгуулж ажиллуулав.	100

2.2.3	БОЭТ-ийг чадавхжуулах Бельгийн Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.	Бүсийн Оношлогоо эмчилгээний төвийг Бельгийн Засгийн газрын чадавхжуулах төсөлд хамруулах судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран шинэчлэн хийж Засгийн газарт уламжилж, аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн дэмжлэгтэйгээр Монголын талаас гаргах санхүүжилтийг 2014 оны улсын төсөвт суулгаж төсөл хэрэгжих бодит нөхцөлийг бүрдүүллээ.	70
2.2.4	Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах бүтцийг буй болгон хэрэгжилтийг сайжруулна.	Засгийн газрын тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн яам тэргүүлэн хэрэгжүүлэх 10 үндэсний хөтөлбөрийн 32 заалтуудыг хяналтад авч гүйцэтгэлийг тооцон ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай мэдээллийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн НЭМ-ийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж ЭМГ-ын дэргэд Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс байгуулагдаж сумдад нийгмийн эрүүл мэндийн ажилтан орон тоогоор ажиллах боллоо.	100
2.2.5	Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээг өргөтгөж Жаргалант өрхийн эмнэлгийн шинэ барилгыг ашиглалтад оруулна.	Жаргалант сумын “Жаргалант” өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг “Алтайн өргөө” ХХК хугацаанд нь чанартай гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.	100
2.2.6	Булган сумын нэгдсэн эмнэлэг, Зэрэг, Чандмань Мянгад сумын эрүүл мэндийн төвийг иж бүрэн гал тогооны цахилгаан хэрэгслээр хангана.	Сумдын гал тогооны судалгааг нэгдсэн байдлаар гаргууллаа. Заалтанд тусгагдсан сумдыг Цөлжилтийг сааруулах төсөлд уламжилж шийдвэрлүүлэх, орон нутгийн төсөвт тусгуулахаар санал хүргүүлээд байна.	30
2.2.7	Манхан сумын ЭМТ-ийн хашаа, мооргийн барилга барьж, Мөнххайрхан сумын ЭМТ-ийн барилгыг засварлана.	Манхан сумын Эрүүл мэндийн төвийн хашаа, мооргийн барилгын тендерийн шалгаруулалтад Ховд аймгийн “Мөнх Алтайн уянга” ХХК шалгарч гүйцэтгэн барилгын ажлыг улсын комисст хүлээлгэн өгөв.	100
2.2.8	БОЭТ болон Ховд, Чандмань сумын эрүүл мэндийн төвийн машиныг шинэчилнэ.	БОЭТ, сумдын машиныг шинэчлэх талаар холбогдох судалгаа хүсэлтийг яаманд уламжилж Чандмань сумын машиныг шинэчлэн, БОЭТ-д ерөнхийлөгчөөс машин олголоо	70
2.2.9	Эх нярайн эрсдэлээс хамгаалах санг өргөжүүлэн, эх хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулна.	Эмзэг ядуу бүлгийн эхчүүд, хүүхдүүдэд чиглэсэн “Эх нярайн эрсдэлээс хамгаалах сан”-гийн журмын дагуу 2 эх, 2 хүүхдийг УБ хотод эмчилгээ хийлгэхэд унааны зардлын дэмжлэг үзүүлж, өндөр настнуудад унааны хөнгөлөлт олгож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох аймгийн зөвлөгөөн зохион байгууллаа.	100
2.2.10	Ховд, Эрдэнэбүрэн, Дарви, Зэрэг, Манхан сумдын эмнэлгийг интернетийн өндөр хурдны шилэн кабельд холбоно.	Буянт, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн, Дуут, Мөнххайрхан, Мөст, Чандмань, Манхан сум интернетийн өндөр хурдны шилэн кабельд холбогдох газарт уламжлаад байна. Дарви, Зэрэг сумын эрүүл мэндийн төвийн мэдээллийг цахимаар нэгтгэж байна.	70
2.2.11	Эрүүл мэндийг дэмжигч сум, баг, байгууллага, хамт олон, гэр бүл шалгаруулан туршлагыг	“Эрүүл хот, сум, баг, ажлын байр, байгууллага, сургууль” бий болгох аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 83 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Эрүүл ажлын байр бий болгох санаачлагыг сум,	100

	түгээн дэлгэрүүлнэ.	байгууллагуудад сурталчлан ажилласнаар аймгийн хэмжээнд 21 сум, өрхийн эрүүл мэндийн төв, 26 ерөнхий боловсролын сургууль, 36 төрийн болон төрийн бус байгууллагууд ажилчдын алжаал тайлах болон чийрэгжилтийн өрөөг тохижуулж, эрүүл мэндийг дэмжигч байгууллага 43, өрх 45 болж өмнөх оны мөн үеийнхээс тус бүр 6-аар нэмэгдсэн байна.	
2.2.12	Бүх сумдын эмнэлэгт лабораторийн анализатор нийлүүлж, мэргэжилтнийг бэлтгэн нэгжид хийгдэх шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Сумдын 16 эрүүл мэндийн төвд нэг удаа 17 параметрийн үзүүлэлтийг 25 хүнд 5 минутын дотор унших хүчин чадалтай биохимийн хуурай аргын анализатор нийлүүлж, сумдын лаборант нарыг сургаж бэлтгэснээр анхан шатны тусламж үйлчилгээний нотолгоонд тулгуурласан оношилгоо, шинжилгээний нэр төрлийг олшруулж иргэдэд хүрэх үйлчилгээний хүртээмжийг дээшлүүллээ.	100
2.2.13	Эмийн сангуудыг батлагдсан стандартын дагуу ажиллуулж, эмнэлгүүдийн стационарт хэрэглэгдэх эмийн 60-аас доошгүй хувийг тендэрээр нийлүүлнэ.	2013 онд БОЭТ болон сумдын ЭМТ-ийн стационарт хэрэглэгдэх 617.3 сая төгрөгийн эмийн тендерт 11 эм ханган нийлүүлэх байгууллага шалгарч чанартай, үйлчилгээний өндөр идэвхтэй эмийг оны эхнээс нийлүүлж, нийт эмийн 74.6 хувийг тендерээр хангах ажлыг зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай эмийн хангалт сумдад 75, аймгийн төвд 84 хувьд хүрсэн байна.	100
2.2.14	Хувийн эрүүл мэндийн байгууллагыг дэмжин үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.	Аймгийн хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулдаг Цагаан уул ахмадын амралт, улирлын чанартай ажилладаг Нэвт рашаан сувилал ажиллаж, үйл ажиллагаанд нь төр захиргааны зүгээс дэмжлэг үзүүлж байна. Хувийн хэвшлийн ортой 5 эмнэлэг, үүдэн 14 эмнэлэг ажиллаж үүдэн эмнэлгийн тоо 3, шүдний хувийн эмнэлэг 2, эмийн сан 1-ээр тус тус нэмэгдлээ.	100
2.3. Хүн ам нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар:			
2.3.1	Жил бүр 500 хүний байнгын ажлын байр бий болгох хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	“Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Ажилтай орлоготой-Ховд хүн” хөдөлмөрийн яармаг, “Хөдөлмөрийн бага чуулган” зэрэг цогц арга хэмжээнүүдийг зохион байгуулан, “Эзэнтэй Монгол хөтөлбөр”, “40-өөс дээш болон ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” зэрэг зорилтот бүлгүүдэд чиглэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 1831 иргэдээс байнгын ажлын байранд 1203, түр ажлын байранд 293, улирлын чанартай ажлын байранд 335 иргэн тус тус зуучлагдаж, 1050 нь байнгын ажлын байраар хангагдлаа.	100
2.3.2	Баруун бүсийн “ажиллах хүчний бирж” байгуулах эхлэлийг тавина.	Ажил идэвхтэй хайж бүртгүүлсэн иргэд 1695, үүнээс эмэгтэй 977 байгаа бөгөөд ажил олгогчдоос сул ажлын байрны захиалга 1165 хүлээн авч, 1831 иргэнийг ажилд зуучилсан байна.	70
2.3.3	Ажил олгогчид ажиллах хүчнээ биржээр дамжуулан авах зохицуулалтыг хийж, бирж дээр суурилсан “иргэн-ажил олгогч” хоорондын бие даасан хамтын ажиллагааг бий болгоно.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг ажил хайгч, ажил олгогчдод хялбар, шуурхай, хүртээмжтэйгээр хүргэх үүднээс ажилд зуучлах бүртгэл мэдээллийн Е-бирж /буюу электрон киоск/-ийг хөдөөгийн 8 сум, аймгийн төвд байрлуулснаар ажил хайж буй иргэн 21 аймаг, нийслэлийн хаана ч байгаа ажлын байрны мэдээллийг нэг дороос авах боломжтой боллоо.	100
2.3.4	“Ажилд авсан хүн тутамд нэг сая төгрөг” хөтөлбөр гарган	“Хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоо нөхөрлөл байгуулах иргэнийг дэмжих” хөтөлбөрт 112 төсөл хүлээн авч, 2 нөхөрлөл, 48 иргэнд нийт 60.0 сая төгрөг олгож нийт 61 ажлын байр,	70

	хэрэгжүүлж ЖДҮ-ийн зээлээр аж ахуйн нэгжийг дэмжинэ.	хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт 212 төсөл хүлээн авч, хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн 29 иргэнийг хамруулж нийт 25.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 29 ажлын байрыг шинээр бий болгосон байна.	
2.3.5	Мэргэжлийн түр сургалтад 450 хүнийг хамруулж, 70 хувийг ажлын байраар хангана.	“Оюу толгой” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй зам, барилга, уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарт үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх төслийн хүрээнд нийт 39 компаниас 406 ажлын байрны захиалга хүлээн авч, ажилгүй, мэргэжилгүй иргэдийг бүртгэн, ажил олгогчтой гэрээ байгуулах ажлыг зохион байгууллаа. Эхний ээлжинд ойжуулалт 29, барилгын засал чимэглэлчин 42, гагнуурчин 14, бетон арматурчин 24, мужаан 13, сантехникч, өрлөгчин, хүнд машин механизмын операторчин 43, цахилгаанчин 19 нийт 253 хүнийг дээрх 9 мэргэжлээр суралцуулж байнгын ажлын байраар хангав.	100
2.3.6	Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн иж бүрэн судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг гаргаж, эрэлттэй байгаа ажлын байрны мэргэжлээр сургах, дадлагыг захиалагч ажлын байран дээр хийлгэх, цаашид тогтвортой ажлын байраар хангах зохицуулалтыг хийснээр нийт 39 компаниас 406 ажлын байрны захиалга хүлээн авч, ажилгүй, мэргэжилгүй иргэдийг бүртгэн, ажил олгогчтой гэрээ байгуулах ажлыг зохион байгууллаа. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, улирал тутам хуралдаж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна.	100
2.3.7	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эх, эцэг, олон хүүхэдтэй эх, хүүхэд зэрэг зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг өргөжүүлнэ.	2013 оны 2 дугаар сараас эхлэн Жаргалант сумын өндөр настнуудыг нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих журам мөрдөж 610 ахмадууд хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 150 иргэний судалгааг гаргасан ба дараа жилээс ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчиход зориулж 25.0 сая төгрөгийг 2014 оны улсын төсөвт тусгуулаад байна.	100
2.3.8	Хүүхэд бүрт сар бүр 20000 төгрөг олгох төрийн бодлогыг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлнэ.	2013 оны 11 сарын байдлаар нийт 32696 хүүхэд бүртгэгдэж, арилжааны 6 банкаар 31555 хүүхдэд 6.9 тэрбум төгрөг олгон 122 хүүхдийн бичиг баримтын зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч байна.	100
2.3.9	Нийгмийн халамж, тусламж авах иргэдийг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлдэг журам гарган мөрдүүлнэ.	Энэ онд аймгийн төв Жаргалант сумын 12 багийн ИНХ-аар нийгмийн халамж, тусламжид хамрагдах иргэдийн асуудлыг өөрсдөөр нь хэлэлцүүлж, 1215 өргөдөл ирснээс 615 иргэн хуулийн дагуу дэмжлэгт хамрагдахаар шийдвэрлэсэн байна. Энэ үйл ажиллагааг 2014 оноос эхлэн хөдөө сумдад зохион байгуулахаар төлөвлөж байна.	70
2.3.10	Ахмад дайчид, хагас бүтэн өнчин хүүхдэд аймгийн Засаг даргын тэтгэлэг олгоно.	2014 оноос хэрэгжүүлэхээр судалгаа, төсвийн тооцоог боловсруулж байна.	50
2.3.11	Ядуурлыг бууруулах цогц хөтөлбөр боловсруулна.	Аймгийн хэмжээнд жил бүр 154 ядуу өрхийн гишүүдийг дэмжиж, амьжиргаанд нь туслах төсөл хөтөлбөрт хамруулж, “Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгүүдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг авснаар 1841 иргэн ажлын байраар хангагдаж, орлогоо нэмэгдүүлсэн байна.	70
2.3.12	Олон нийтэд	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	100

	түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор зорилтот бүлгүүдэд хүргэнэ.	үзүүлэх иргэний нийгмийн байгууллагуудыг шалгаруулах тендер зарлан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэргээн засах үйлчилгээг аймгийн “ХБХЭЭ-ийн Холбоо” ТББ-аас гэрээгээр гүйцэтгүүлж, нийгмийн халамжийн сангаас 2.1 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.	
2.3.13	“Ажилласан жил, тэтгэвэрийн даатгалыг нөхөн тооцох” тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	“Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18306 хүн хамрагдаж, ажилласан жилээ нөхөн тооцуулж, энэ ажил 107 хувийн биелэлттэй хэрэгжлээ.	100
2.3.14	Баруун бүсийн хүүхэд залуучуудын хүрээлэнг өргөтгөж, Баянбулаг хүүхдийн зуслангийн барилгыг засварлан ажиллуулна.	Улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгөөр Баянбулаг зусланг “Буянтын боргио” ХХК засварлаж, улсын комисс хүлээж авлаа.	100
2.3.15	Орон нутгийн телевизэд “Гэр бүлийн цаг” байнгын нэвтрүүлгийг буй болгож, тогтмолжуулна.	“Гэр бүлийн цаг” нэвтрүүлгийг сард 1 удаа “Ховд” телевизтэй хамтран явуулж байна.	100
2.3.16	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр нийгмийн ажилтнуудыг чадавхжуулна	Нийгмийн ажилтнуудыг лицензжүүлэх 2 үе шаттай сургалтын эхний шатны сургалтыг НХҮЕГ болон МУБИС-тай хамтран зохион байгуулж 35 нийгмийн ажилтан хамрагдаад байна.	70
2.3.17	Гэр бүл, жендэрийн асуудлаар мэргэшсэн, сургагч багш нарыг сум, байгууллагуудад бэлтгэн, жендэрийн тэгш байдлын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна.	Жендэрийн салбар бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.	70
2.3.18	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетыг байгуулж, эрэгтэйчүүдэд зориулсан үзлэгийн цагтай болгоно.	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эрэгтэйчүүдийн кабинетийг өдрийн 8 цагаар ажиллуулж, 134 эрэгтэй үйлчлүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгт 596 эрчүүд хамрагдсан байна.	90
2.3.19	Төсвийн захиран зарцуулагч нарт жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн арга зүйг эзэмшүүлэх, шийдвэр гаргагч нарт хөгжлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох сургалт, сурталчилгааны ажлыг үе шаттайгаар зохион байгуулж	Жендэрийн үндэсний хорооноос сургалт авах талаар ярилцаж байгаа бөгөөд жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй үйл ажиллагаануудын талаар холбогдох мэдээллүүдийг тухай бүр цахимаар солилцож байна.	90

	чадавхжуулна.		
2.3.20	Удирдах албан тушаалд сонгогдсон болон томилогдсон, мэргэжлийн салбартаа бэлтгэгдэж чадваржсан эмэгтэйчүүдийн манлайлал, мэдлэг үр чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.	Орон нутгийн сонгуулийн үр дүнд аймгийн хэмжээнд сумын Засаг дарга 2, сумын Засаг даргын орлогч 2, сумын Засаг даргын Тамгын газрын дарга 3, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн дарга 2, аймгийн ИТХ-ын ажлын албаны хэлтсийн дарга 1, Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагын дарга 8 эмэгтэйчүүд удирдах албан тушаалд томилогдон ажиллаж байгаа бөгөөд аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөл болон бусад төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.	100
Гурав. Эдийн засаг, үйлдвэрлэл, худалдаа, дэд бүтэц, барилга, хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хүрээнд:			
3.1. Санхүү эдийн засаг, төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар:			
3.1.1	Аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тогтоон, үр нөлөө, үр ашигтай арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх бодлого баримтална.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны болон аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, иргэдийн олонхийн санал авсан хөтөлбөр, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх бодлого баримтлан ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 9588,4 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 423,5 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 54017,8 сая, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 25,0 тэрбум, нийт 89029.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.	90
3.1.2	Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, иргэд, олон нийтийн хяналт, оролцоонд тулгуурлан тендерийн будлиан, чанаргүй гүйцэтгэл, авлига, хээл хахуулийг таслан зогсооно.	Худалдан авах ажиллагааны үйл ажиллагааг ил тод нээлттэй зарлаж, аймгийн худалдан авах ажиллагааны вэб сайт нээн энэ онд зохион байгуулсан бүх худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байршуулан олон нийтэд сурталчилж ажиллалаа.	100
3.1.3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд аудит хийлгэн, үнэлэлт, дүгнэлт өгөх замаар хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн үр ашгийг дээшлүүлнэ.	ОНХС болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих, үнэлгээ хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2013 оны А/407 дугаар захирамжаар байгуулан энэ онд батлагдсан хөрөнгө оруулалтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд хяналт тавин ажиллаж байна.	90
3.1.4	Төсвийн шинэчлэлийн хүрээнд төсвийн байгууллагын эдийн засагч, нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулж, шинэ хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.	Сангийн яам, аймгийн СТСХ хамтран 4 дүгээр сард төсвийн байгууллагуудын захирагч, сумын төвийн багийн дарга, төрийн сангийн төлөөлөгч зэрэг 200 гаруй хүнд Төсвийн тухай хууль, шинэчлэгдэн гарч байгаа заавар, журмуудын талаар 2 өдрийн сургалт явууллаа. Энэ сургалтыг орон нутагт 2 дахь удаагаа хийсэн нь төсвийн захирагч, санхүүгийн ажилтнууд төсвийн хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх боломж бүрдэж байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 143, 2012 оны 17 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7 дахь заалтыг хэрэгжүүлэхээр төсвийг ил тод, нээлттэй иргэд, олон нийтэд мэдээлж байх талаар аймгийн Засаг даргын 2013 оны	90

		<p>A/135,136 дугаар захирамжуудыг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Нээлттэй нийгэм форумтай хамтран төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор www.khovdtusuv.wordpress.com сайтыг 2012 оны 8-р сараас эхлэн туршилтын журмаар ажиллуулж байгаад энэ оны 2-р улирлаас уг төсөл дуусаж аймгийн www.khovd.gov.mn сайт болон Нийтийн номын сан, байгууллага бүр мэдээллийн самбараар төсвийн мэдээллийг иргэд, олон нийт, сонирхсон хүмүүст мэдээлж байна. Цаашид өөрийн гэсэн төсвийн мэдээллийн сайттай болох талаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	
3.1.5	Татварын багц хуулийн хүрээнд орон нутагт хувь хэмжээг тогтоох татварыг шинэчлэн тогтоож, татварын бааз, суурийг нэмэгдүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлж, татварын үйл ажиллагаанд онлайн системийг үе шаттай нэвтрүүлнэ.	<p>Байгалийн ургамал, усны нөөц, рашаан, түгээмэл ашигт малтмалын байгалийн нөөц ашигласны төлбөрүүдийн татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг аймгийн ИТХ-аар батлуулснаар өмнөх жилийн гүйцэтгэлээс 2013 оны тухайн төрлийн татварын орлогын төлөвлөгөө 136,4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.</p> <p>Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөө гарган 337 хамаарагчтай 130 агуулагчтай 282 татвар төлөгчийн 363 ширхэг 3904,9 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулж 6160,4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 114,5 сая төгрөгийн нөхөн татвар, 11,4 сая төгрөгийн алданги, 38,0 сая төгрөгийн торгууль, 56.2 мянган төгрөгийн хүү ногдуулсан.</p> <p>Энэ онд татвар төлөгчдийн бааз суурийг өргөтгөх, хүрээг нэмэгдүүлэх, татварын хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор давхардсан тоогоор 130 гаруй төсөвт болон ААНБ –ын 1626 хүнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сурталчилгаа хийж, гарын авлага материалаар хангаж ажилласны дүнд татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо 2012 оноос 1935-аар нэмэгдэн 21517-д хүрсэн байна.</p> <p>“Цахим татварын алба” хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 640 татвар төлөгчдөд Татварын ерөнхий газраас цахим татварын тайлангийн сургалтыг зохион байгуулж аймгийн хэмжээнд 906 татвар төлөгч ААНБ-ын тоон гарын үсэг авсан нь бүртгэлтэй татвар төлөгчийн 75.5 хувийг эзэлж байна.</p>	90
3.1.6	Сангуудын удирдлагын менежментийг боловсронгуй болгож, зарцуулалтын үр ашгийг сайжруулж, ил тод нээлттэй болгоно.	Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, олгосон зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн судалгааг 17 сумаас авч нэгтгэн дүгнэлт хийж авсан зээлийн зориулалтын байдалд хяналт тавих, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах талаар сумдад албан бичгээр үүрэг чиглэл өгөв. Одоогийн байдлаар аймагт 6 төрлийн сан байгаа бөгөөд сангуудын судалгаа гаргаж зарим зориулалт адилхан сангуудыг ОНХС-д нэгтгэхээр бэлтгэж байна.	70
3.1.7	Төсвийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын нягтлан бодогч нарыг мэргэшүүлж, сэлгэн ажиллуулах арга хэмжээ авна.	Нягтлан бодогч нарын ажлыг дүгнэх, сэлгэн ажлуулах ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулж, төрийн сангийн ажилтнууд, аймгийн төвийн нягтлан бодогч нарт цаг үеийн ажил, хариуцсан ажлаа хариуцлагатай хийж, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулан оны эцэст өр, авлагагүй гарах талаар семинар, зөвлөмж, үүрэг чиглэл өгч, 2014 онд хийхээр хойшлуулав.	90
3.1.8	Төрийн сангийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгон, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, өр, авлагагүй ажиллана.	Манай аймгийн төрийн сангийн системд нийт 210 байгууллагын 844 данс байршиж байгаагаас аймгийн төвийн улсын болон орон нутгийн мөнгөн урсгалын гүйлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хийж харилцагч байгууллага, иргэдэд санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай гүйцэтгэж байна. Төсвийн 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн урсгал зарлага 16306,4 сая төгрөг хүрч, тодотгосон	90

		<p>төлөвлөгөөнөөс 166,5 сая төгрөгөөр хэмнэгдэж гарахаар байна. Энэ нь халамжийн сан 264,6 сая төгрөгөөр хэмнэгдэж, бусад байгууллагын нийт зарлага 95,0 сая төгрөгөөр давж гарахаар байна. Давж гарч байгаа зарлагаас сумдын өмнөх оны болон энэ оны давсан орлогоос зарцуулсан 55,0 орчим сая төгрөгийг хасаж тооцоход 40,0 орчим сая төгрөгийн өртэй гарах урьдчилсан дүнтэй байна. Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын төсвийн зарлага урьдчилсан байдлаар 31627,6 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 138,3 сая төгрөгөөр давж өртэй гарч болзошгүй байна. Өрийг салбараар авч үзвэл Эрүүл мэндийн салбарын сумдын эрүүл мэндийн төвүүд 86,0, ССАЖС-ын байгууллагуудын өр 40,3, хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс 11,3 сая төгрөг тус тус байна</p>	
3.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний талаар:			
3.2.1	<p>100 жижиг, дунд үйлдвэр, 2000 хүний тогтмол ажлын байр аймгийн хөтөлбөр санаачилж батлуулна. ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн эргэлтийн сангийн эх үүсвэрийг 5 тэрбум төгрөгт хүргэж, зээлийн сангийн хөрөнгийг иргэдийн оролцоонд тулгуурлан, шударга ил тод байдлаар хуваарилдаг тогтолцоонд оруулна.</p>	<p>Суманд үйлдвэр хөгжүүлэх асуудлыг сумдын Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгаж, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 2.3 тэрбумаар нэмэгдүүлэн иргэд аж ахуйн нэгжид үйлдвэр байгуулах, үйлдвэрээ өргөтгөх чиглэлээр зээл олголоо. Жаргалант суманд 10 аж ахуйн нэгж, 43 иргэнд 589.78 сая төгрөгийн зээл олгосон. Одоогоор 17 сумын 325 иргэн аж ахуйн нэгжид 2448.4 сая төгрөгийн зээл олгоод байна.</p>	70
3.2.2	<p>Баруун бүсийн худалдааны төв-битүү зах байгуулах зураг төсөв, судалгааг хийж барих ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Битүү худалдааны төв байгуулах тендерт “Ус-орчин” ХХК шалгарч 8200 м.кв талбай бүхий 600 гаруй хүн худалдаа эрхлэх хүчин чадалтай худалдааны битүү зах байгуулах барилгын ажил хийгдэж 12 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p>	100
3.2.3	<p>Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид, иргэдийг зохион байгуулалттайгаар гадаад улс оронд технологийн туршлага судлах, шинэ санаа олж ирэх бизнес аялалд хамруулна.</p>	<p>Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын ШУӨЗО-ны зарим аймаг, хотод туршлага судлах аялалыг зохион байгуулав. Аймгийн ХАҮТ, ХБХ-ээс Герман улсад туршлага судлах аялалд хамрагдлаа.</p>	100
3.2.4	<p>Импортоор оруулж буй хүнсний чанарт тавих хяналтыг чангатган дээж авч шинжилгээ хийсний үндсэн дээр оруулна. Ярантын хилийн боомт дээр барилга хүнсний иж бүрэн шинжилгээний лаборатори шинээр байгуулна.</p>	<p>Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лаборатори нь 2077 бүтээгдэхүүний сорьцонд 6288 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 330 эерэг сорьц илэрсэн байна. Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хилээр оруулж ирэхийн өмнө бүтээгдэхүүний загвар дээжийг шинжилгээнд хамруулж 71 удаа импортын мэдэгдэл олгосон байна. Лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэхэд 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, барилгын материалын тоног төхөөрөмж нийлүүлэгдэн боловсон хүчнийг сургалтанд хамрууллаа.</p>	70
3.2.5	<p>Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ технологи, стандартыг мөрдүүлэн, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтын стандартад тогтмол хяналт хийж, бараа бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. “Баялаг-Буянт” ХХК-ний хүнсний ногооны нөөшлөх үйлдвэр байгуулагдаж 3 нэр төрлийн салат хийж худалдаанд нийлүүлэгдээд байна. Ховд аймгийн хэмжээнд 791 иргэн аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэр үйлчилгээ эрхэлж байгаа бөгөөд энэ нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлж байна. МХГ азраас хэрэглээний баталгаат хугацаа дуусаж чанар</p>	90

		байдлаа алдсан 52 нэр төрлийн 970.7 мян төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг хураан авч хүн амын хүнсний хэрэгцээнээс хассан байна.	
3.2.6	Улаанбаатар хотод Ховд аймгийн төлөөлөгчийн газар байгуулж, төмс хүнсний ногоо хадгалах 1000 тонн хүртэл багтаамжтай зоорь байгуулах газрын болон хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ. Аймгийн брэнд бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо борлуулах цэгүүд байгуулна.	Улаанбаатар хотод Ховд аймгийн төлөөлөгчийн газар нээх байрны асуудлыг шийдвэрлэхээр орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө тусган байр авахаар тендер зарласан боловч тендерт оролцох санал ирээгүй байна. Засгийн газраас Улаанбаатар хотод нэгдсэн байдлаар хүнсний ногооны томоохон хэмжээний зоорь барих ба Ховд аймагт хэсэгчлэн олгох болсон.	50
3.2.7	Аймгийн төвд баригдаж буй ахуйн үйлчилгээний төвийн барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.	Аймгийн төвд баригдаж буй ахуй үйлчилгээний барилгын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох хяналтын байгууллага, гүйцэтгэгчид үүрэг чиглэл өгсөн. Гэрээний ерөнхий нөхцөлд 2012 оны 7-р сард хүлээлгэн өгөхөөр тусгагдсан боловч одоо хүртэл барилгын ажлаа хүлээлгэн өгөлгүй удааширч байгаа тул Засаг даргын орлогчийн 2013 оны 09-р сарын 20-ны өдрийн 1/2100 тоотор барилгын ажлыг энэ онд багтаан ашиглалтад оруулах үүрэг өгөгдсөн бөгөөд ашиглалтад оруулаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлуулах асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх үүрэг өгсөн болно.	70
3.2.8	Мэргэжлийн хяналтын газрын лаборатори байгуулж, ашиглалтад оруулна.	Ярант боомтын хими ургамал хорио цээрийн лаборатори нь 11 нэр төрлийн тоног төхөөрөмж 14 нэр төрлийн эм урвалж бодистойгоор 2013 онд 244 дээжинд 1226 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 2 дээж эерэг үзүүлэлттэй гарсан байна. Хүчин чадлыг нэмэгдүүлэх, багаж хэрэгсэл, урвалж бодисын захиалгыг аймгийн МХГ-аар дамжуулж хүргүүлж ажиллаж байна. Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилга барихад зориулж 2014 оны улсын төсөвт 570.0 сая төгрөг тусгууллаа.	100
3.3. Дэд бүтцийн талаар:			
3.3.1	Ховд-Манхан чиглэлийн 85.3 км, Өлгий-Хашаатын даваа чиглэлийн 60 км, Манхан-Дарви чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замуудыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулна.	Ховд-Манхан чиглэлийн 85.3 км, замын ажил бүрэн хийгдэж дууссан, Манхан-Дарви чиглэлийн 100 км хатуу хучилттай авто замын ажлын 80 хувь нь хийгдсэн Өлгий-Хашаатын даваа чиглэлийн 60 км замын ажил хийгдэж дуусаад байна.	100
3.3.2	"Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төсөл"-ийн Бага улаан даваа-Тэмээн хүзүү чиглэлийн 110.8 км, Манхан-Бага улаан даваа чиглэлийн 103.3 км, Булганы Хөвч-Үенч, Үенч-Тэмээн хүзүү чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барина.	"Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын төсөл"-ийн Бага улаан даваа-Тэмээн хүзүү чиглэлийн 110.8 км, Манхан-Бага улаан даваа чиглэлийн 103.3 км, Булганы Хөвч-Үенч, Үенч-Тэмээн хүзүү чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барих ажлын хүрээнд гүүр далангийн ажил бүрэн хийгдэж дууссан, хучилтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангасан байна.	100
3.3.3	Мянгадын гүүр-Сар хайрхан чиглэлд 20 км хатуу хучилттай зам барих ажлыг эхлүүлнэ.	Мянгадын гүүр-Сар хайрхан чиглэлд 20 км хатуу хучилттай зам барих ажлыг эхлүүлж замын шороон далан, сувгийн ажлыг гүйцэтгээд байна.	100
3.3.4	Аймгийн төвийн 7.1 км хатуу	Замын ажил хийгдэж эхний ээлжийн 4.6 км замыг	70

	хучилттай авто замын барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.	ашиглалтад хүлээлгэн өгсөн.	
3.3.5	Талын хашааны цэвэр, бохир усны шугам, сүлжээний өргөтгөл хийж, хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэнэ.	Талын хашааны цэвэр, бохир усны шугам, сүлжээний өргөтгөл хийж, хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын хүрээнд цэвэр усны 8 км, бохир усны 3.8 км шугам сүлжээний ажлыг хийж, 2 ш 500 метр куб багтаамжтай усан санг хийсэн боловч нэг нь туршилт даалгүй гэмтсэн байгаа, өргөлтийн насос станцын суурь тохирохгүй байгаа гэдэг шалтгаанаар ажил зогссон байна. 4200 м/куб хүчин чадал бүхий хотын нэгдсэн цэвэрлэх байгууламжийн ажил хийгдэж байна.	50
3.3.6	Дулааны хоёрдугаар эх үүсвэрийн барилга, шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	Дулааны хоёрдугаар эх үүсвэрийн барилга, шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эхлүүлж зуухны барилга тоног төхөөрөмж угсралтын ажил 80%, шугам сүлжээний ажил ЦТП-гийн барилгын асуудлаас бусад ажил хийгдэж дуусаад байна.	100
3.3.7	Ард-Аюушийн талбайн шинэчлэлийн ажлыг дуусгаж, тохижуулна.	Ард-Аюушийн талбайн шинэчлэлийн ажлыг дуусгаж, тохижуулах ажил удаашралтай явагдаж материал бэлтгэхэд цаг хугацаа орж байна. Гүйцэтгэгч компанид үүрэг даалгавар өгч ажиллаа.	30
3.3.8	Аймгийн төвд явган хүний замыг шинээр тавих буюу хэсэгчлэн шинэчлэнэ.	Аймгийн төвд явган хүний замыг шинээр тавих буюу хэсэгчлэн шинэчлэх талаар шинээр 8 км явган зам тавьж, 14 мянган метр квадрат авто зогсоол хийж, 2 автобусны буудал шинээр хийж, 600 гаруй машин зогсох боломжийг бүрдүүллээ	100
3.3.9	Ховд хотын нисэх буудлыг тохижуулж, уулзалт зөвлөгөөний вип танхимтай болгоно.	Ховд хотын нисэх буудлыг тохижуулж, уулзалт зөвлөгөөний вип танхимтай болгосон.	100
3.3.10	Хотын нийтийн тээврийн үйлчилгээг өргөтгөн өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан сурагчдыг хөнгөлөлтөд хамруулна.	Хотын нийтийн тээврийн үйлчилгээг өргөтгөн өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан сурагчдыг хөнгөлөлтөд хамруулах талаар арга хэмжээ авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд асуудал тавьж шийдвэрлэв.	100
3.3.11	Аймгийн зарим багийн төвийг үүрэн холбооны сүлжээнд холбоно.	Аймгийн зарим багийн төвийг үүрэн холбооны сүлжээнд холбох ажлын хүрээнд 9 сумын төвийг шилэн кабельд холбож, 11 цэгт Жимобайлийн үйлчилгээг оруулан багийн төвүүдэд үүрэн сүлжээг ашиглаж байна.	100
3.3.12	Аймгийн төвийн Талын хашаа чиглэлд шинээр цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц байгуулан Их голын хойд гэр хороололд цахилгааны шугам татаж, эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ.	Аймгийн төвийн Талын хашаа чиглэлд шинээр цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц байгуулан Их голын хойд гэр хороололд цахилгааны шугам татаж, эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баатархайрхан, Алагтолгой, Бичигт багт 250 кВт трансформатор тавьж хүчдэлийг нэмэгдүүлэв, Монгол банк, холбооны дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүллээ.	50
3.3.13	Шинэ орон сууцны хотхон байгуулах төлөвлөлт, зураг төсөв хийж, баруун бүсийн барилгын материалын лаборатори байгуулна.	Шинэ орон сууцны хотхон байгуулах төлөвлөлт, зураг төсөв хийж, баруун бүсийн барилгын материалын лаборатори байгуулах ажлын хүрээнд 4,3 га талбайд төлөвлөлт хийж 456 айлын орон сууцны хорооллыг цэцэрлэг үйлчилгээний төв, харуул хамгаалалттай ногоон байгууламж байхаар зураг төсвийг хийж хөрөнгө оруулалтыг шийдэн эхлүүлэх ажлыг зохион байгуулж байна. Бүсийн лабораторийн барилгыг барих газрын асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.	70

3.3.14	Ирэх жилүүдэд хийгдэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг хийлгэнэ.	Ирэх жилүүдэд хийгдэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг хийлгэх талаар аймгийн төвд баригдах 10.1 км авто замын зураг, 4,3 га"-д хийгдэх 456 айлын хороолол, шинэ суурьшлын бүс, амины хаус хороолол, чулууны үйлдвэр, ХАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж зэргийн зураг төсвийг боловсруулан холбогдох газруудад хөрөнгө оруулалтын саналыг тавьж ажиллав. Энэ онд 350.0 сая төгрөгийн эх үүсвэр бүхий зургийн сан байгууллаа.	100
3.4. Барилга, хот байгуулалт, газрын харилцааны талаар:			
3.4.1	Ховд хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн баталж, Монгол улсын жишиг "Ховд хот" хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвгөөг батлуулж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэж 2014 онд багтаан ерөнхий төлөвлөгөөг хийлгэхээр гэрээ хийн ажлыг эхлүүлээд байна. Төсөвт өртөг 1285,0 сая төгрөг	50
3.4.2	Ховд хот болон сумдын төвд шинээр орон сууц барина.	Аймгийн төвд 125 айлын орон сууц, суманд 10 айлын орон сууцыг ашиглалтад хүлээн авсан. Энэ онд багтаан 196 айлын орон сууцыг ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.	100
3.4.3	Хууль зөрчин олгосон хотын доторх болон Буянт голын ай сав дагуух газрыг чөлөөлж, нийтийн эзэмшилд шилжүүлнэ.	Хууль зөрчин олгосон хотын доторх болон Буянт голын ай сав дагуух газрыг чөлөөлж, нийтийн эзэмшилд шилжүүлэх талаар газар олголтонд хяналт тавьж зөрчилтэй байгаа газруудын тоог гарган хууль хяналтын байгууллагад шийдвэрлүүлэхээр хандаад байна.	90
3.4.4	Газрын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, өмчлүүлэх, эзэмшүүлэх газрыг аймаг, сумын хэмжээнд нарийвчлан тогтоож, 2013 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг ИТХ-аар батлуулан мөрдөнө.	Газрын тухай хуулийг хэрэгжүүлж, өмчлүүлэх, эзэмшүүлэх газрыг аймаг, сумын хэмжээнд нарийвчлан тогтоож, 2013 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг ИТХ-аар батлуулан мөрдөн ажиллаж байна.	90
3.4.5	Хувийн хашаа, орон сууцны хороолол байгуулах газрыг нэгдсэн журмаар гаргаж инженерийн байгууламжийг байгуулан иргэд өөрсдөө орон сууц барих нөхцөл бүрдүүлнэ.	2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулан нийт 3800 газар авах иргэний асуудлыг шийдвэрлэн шинэ суурьшлын бүс байгуулан инженерийн дэд бүтцийг шийдвэрлэн ажиллаж байна.	90
3.4.6	Оршин суугчид нь орц байшингаараа санал нэгдсэн хуучин орон сууцнуудын дээвэр, орц, шатыг засварлан орон сууцны хороолол дахь авто болон явган хүний замыг шинэчлэнэ. Орон сууцны хорооллуудын орчимд чийрэгжүүлэх төхөөрөмж, сүү цагаан идээ худалдаалах стандартын шаардлага хангасан цэгүүд байгуулж эхэлнэ.	Энэ ажлын хүрээнд 30 айл, 72 айл орчмын хороолол доторх авто замыг шинэчлэн хийж явган хүний болон авто машины зогсоолыг шинээр хийв. Нийт 400 машины зогсоол, 0,750 км хар зам, 0.8 км явган замыг хийжээ. Мөн 3 дугаар 60 айл, 27 айлын барилгын дээврийг бүрэн засварлаж, 80 айл, 120 айл, 72 айлуудын сантехникийн угаалга цэвэрлэгээ, шугамыг сольж холболтыг өөрчлөн сайжруулав. 62, 52, 48, 36 зэрэг байрны орцны хаалга засварлав.	90
3.4.7	Цэвэр усыг ахуйн болон үйлдвэрлэлд хэмнэлттэй хэрэглэх зорилгоор айл өрх, албан газар, үйлдвэр, үйлчилгээний газруудыг усны тоолууртай болгоно.	Үнэ өндөр гарч байгаа тул дахин хяналт шалгалт хийх усны тоолуурын стэнд авах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.	50
3.4.8	Цементийн үйлдвэр байгуулах асуудлаар судалгаа хийж барих ажлыг эхлүүлнэ.	Буянт сумын нутаг дэвгэрт газар олголтыг хийж, Цементийн үйлдвэр байгуулах урьдчилсан ТЭЗҮ боловсруулсан, Засгийн газрын бодлогоор Ховд аймагт барих саналыг дэмжсэн.	50

3.4.9	Жаргалант сумын хил заагийг өргөтгөх асуудлаар Ховд, Буянт сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд санал хүргүүлнэ.	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаатай холбогдуулан санал гаргаж ажиллаж байна.	30
Дөрөв. ХАА, байгаль орчны бодлогын хүрээнд:			
4.1. Хөдөө аж ахуйн талаар:			
4.1.1.	Малчид, тариаланчдын бүлэг хоршоо, нөхөрлөл байгуулах санал санаачлагыг дэмжиж ажиллана.	Өнгөрсөн онд Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж 17 сумын малчдын бүлэг, хоршооны 42 төсөлд улсын төсвөөс 340,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр 80-100 хүн түр болон бүр ажлын байраар хангагдлаа.	90
4.1.2.	Малчдын залуу халааг бэлтгэх аймгийн дэд хөтөлбөр санаачилна.	Малчдын залуу халаа бэлтгэх аймгийн дэд хөтөлбөрийг сум, баг, мэргэжлийн байгууллага болон 17 сумын 18-35 насны 220 гаруй малчны саналыг авсны үндсэн дээр боловсруулж аймгийн залуу малчдын сургалт семинарын үеэр хэлэлцүүлж урьдчилсан байдлаар баталгаажуулах ажлыг хийгээд байна. 6 бүлэг 48 заалт бүхий хөтөлбөр боловсруулж батлуулахад бэлэн болоод байна.	70
4.1.3.	Сумдад “Малжуулах сан” байгуулж, залуу малчид, зуданд малаа алдсан иргэдийг малжуулах хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ.	Орон нутгийн хөгжлийн сангаас бүх сум малжуулах сан байгуулж багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг үндэслэн малжуулах ажлыг зохион байгуулж байна. Малжуулах санд орон нутгийн хөгжлийн сангийн нийтдээ 940.0 сая төгрөг тусгагдсан байна. Малжуулах сангийн үлгэрчилсэн дүрмийг аймгийн ИТХ-аас баталсан.	100
4.1.4.	Сумдад малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх, зах зээлд нийлүүлэх тогтолцоог бүрдүүлж, хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн брокерийн үйл ажиллагаа явуулах санаачилгыг дэмжинэ.	ХАА-н гаралтай бараа түүхий эдийн биржийн хуулийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор Мөст сумын Баянтөл, Чандмань сумын Чандмань хөх уулс, Дуут сумын Хүрэн хонх, Дөргөн сумын Дөргөн малчдын хишиг, Жаргалант сумын Ойрдын таван эрдэнэ, Цэвэрлэх булаг хөдөө аж ахуйн хоршоонуудад ноос пресслэгч, цахилгаан жин, таар, төмөр утсыг гэрээ байгуулан олголоо. ҮХАА-н яамнаас Мөст “Цэвэрлэг булаг” хоршоонд 100,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, ХАА-н түүхий эд бэлтгэлийн склад, агуулах барих үйл ажиллагааг дэмжин Үенч сумын Малчны-Ирээдүй, Манхансумын ХИНЦ, Мөнххайрхан сумын Алагийн буурал, Дуут сумын Алтайн цэнхэр уулс, Буянт сумын Буянт-Алтайн үрс, Дөргөн сумын Дөргөн-Малчдын хишиг, Эрдэнэбүрэн сумын Тунгалаг-Уст-Шураг хоршоонуудад тус бүрт нь 9,5 сая төгрөг, нийт 66,5 сая төгрөг олголоо. Аймгийн төв Жаргалант суманд “Гурван цаст-гал тамга” компани ХАА-н биржийн арилжаанд зуучлагч брокерийн тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна.	90
4.1.5.	Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг шинээр гаргах буюу сэргээн засварлана.	2013 онд “Эвлэл” ХХК улсын төсвийн 154024875,0 төгрөгийн санхүүжилтээр 10 худаг гаргахад 7 худаг, Алтайн хар сувд ХХК улсын төсвийн 158753484,0 төгрөгийн санхүүжилтээр 10 худаг гаргахад 7 худаг, аймгийн дүнгээр нийт 20 худаг шинээр гаргахад 14 гарсан байна.	90
4.1.6.	“Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлж малыг эрүүлжүүлэх, бүртгэлжүүлэх, малчдын үндэсний үйлдвэрт тушаасан ноосонд урамшуулал олгох ажлыг зохион байгуулна.	2013 онд 6973 өрхийн хонины 721,3 тн, тэмээний 55,7 тн нийт 777,0 тн ноосны урамшуулалд 1554,0 сая төгрөгийн урамшуулал олгох материалыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны “Мал хамгаалах сан”-д хүргүүлж, энэ онд багтаан олгох арга хэмжээ авна. Нийт малчин өрхийн 90 гаруй хувь нь хамрагдлаа.	100

4.1.7.	Хүлэмжийн аж ахуй байгуулах иргэд, аж ахуйн нэгжийг зээлийн бодлогоор дэмжин шинэ ургацын хүнсний ногоогоор иргэдийг тасралтгүй хангах ажлыг эхлүүлнэ.	Нийт 946 м.кв талбай бүхий 15 хүлэмжийн аж ахуй үйл ажиллагаа явуулж байна. Өргөст хэмх, улаан лооль, сонгино, чинжүү тариалж, 4,4 тонн ургац хураан авсан дүн мэдээтэй байна.	90
4.1.8.	Буянт голын услалтын системийн ажлыг үргэлжлүүлэн 1000 га-д байгуулна.	"Эвлэл" ХХК-ний хүсэлтийн дагуу 2013 оны 5 дугаар сарын 10-д улсын комисс ГС-3 услалтын систем дээр ажилласан боловч уг услалтын системийг комисс хүлээж авах боломжгүй байсан учир хугацаатай үүрэг даалгавар өгсөн боловч одоог хүртэл хүлээлгэж өгөөгүй байна. Уг ажилд Аудитын шалгалт оруулахаар төлөвлөж байна. Буянт голын 2400 га-гийн услалтын системийн 3 дахь ээлжийн 5 км сувгийн ажлыг Ховд сумын Улаан бураа багийн төв дагуу гүйцэтгэхээр Улаанбаатар хотын "Монгол менежмент төв" ХХК аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна.	50
4.1.9.	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж барина.	Ховд аймагт Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-г ҮХААЯаман дээр боловсруулсан. Орон нутгаас газрын асуудлыг шийдвэрлэж улсын төсвийн хөрөнгөөр 2 худаг гаргасан, хашаа, түүхий эд хүлээж авах стандартын агуулах, машины граж зэрэг барилга байгууламжийг бариж гүйцэтгээд байна.	30
4.2. Байгаль орчны талаар			
4.2.1	Үйлдвэрлэл, зам, барилга, геологи, уул уурхайн хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэгжиж байгаа төслүүдийг байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд хамруулж нөхөн сэргээлтийг хийлгүүлнэ.	2013 оны 11-р сарын 22-нын өдрийн байдлаар 8 аж ахуйн нэгжийн шинээр барих барилга байгууламжид байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийснээс 5 аж ахуйн нэгж нөхцөл болзолтойгоор, 3 аж ахуйн нэгж нарийвчилсан үнэлгээ хийлгэх болсон. Байгаль орчны үнэлгээний хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан 17 сумаас үнэлгээний судалгаа авч нэгтгэн гаргаж байна	100
4.2.2	Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг эко системийг судалж тогтоон, тухайн нутгийн нийгэм-экологийн тогтолцооны дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтөөс болж эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх зорилгоор ОХУ-ын Экологи инноваци төвтэй хамтран био бордоо, үрсэлгээний техник технологи турших ажлыг амжилттай хэрэгжүүллээ. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар орон нутагт хийгдэх ажлын төлөвлөгөө гарган батлуулсан. Уур амьсгалын аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж дууссан бөгөөд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2013 оны 12-р сарын хуралдаанд оруулахад бэлэн болоод байна.	90
4.2.3	Орон нутгийнхаа байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах зорилгоор байгуулагдан ажиллаж буй малчдын бүлэг, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг дэмжинэ.	Тохомт сан байгуулсан ба уг сангаар дамжуулан малчдын бүлэг, нөхөрлөлүүдийг туршлага судлуулж, менежмент төлөвлөгөө боловсруулах ажилд хамтран ажилласан болно.	100

4.2.4	Аймаг, сумдын төвд ногоон байгууламж буй болгох, мод тарих ажлыг эрчимжүүлж урамшуулал олгодог тогтолцоог нэвтрүүлнэ.	Ховд аймгийг “Ногоон соёл, иргэншилтэй” загвар аймаг болгох Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 4-р сарын 17-ны өдрийн 55 тоот тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлд аймгийн Засаг даргын 06 тоот албан даалгавар гаргаж ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажлыг хийж байна. Сум бүрт 2 кг олон наст зүлэгний үр, 70 ширхэг жижиг ууттай цэцгийн үрийг зөвлөмжийн хамт хүргүүлж, жилийн эцсээр ажлыг дүгнэж урамшуулахаар ажиллаж байна. Бүх нийтээр мод тарих өдөрт 128 албан газар аж ахуйн нэгжийн 4991 албан хаагч, иргэд оролцож аймгийн хэмжээнд 59014 ширхэг мод бут тариалснаас Үенч сумын 50 га-д мод тарьсан мод 100% амьдралтай ургасан байна.	70
4.2.5	Байгаль экологийн өвөрмөц тогтоцтой, ховордсон ургамал, амьтан элбэгтэй газар нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтанд авах үндэслэл боловсруулж, шийдвэр гаргагчдад хүргүүлнэ.	Булган, Цэцэг, Дарви, Зэрэг, Ховд, Мөст, Эрдэнэбүрэн сумдын орон нутгийн болон улсын тусгай хамгаалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх саналыг БОАЖЯамны сайдад хүргүүлж, ШУА Газарзүйн хүрээлэнгийн эрдэмтдийн судалгааны баг сумдад ажилласан. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүүжилтээр доктор Б.Оюунгэрэл ахлагчтай баг ажиллаж ГИДЦГ-ын “б” хэсэг, Сутай, Баатарын нуруу, Хөх сэрхийн БЦГ-ын хилийг өргөтгөх зэрэг ажлуудыг хийж, аймгийн ИТХТэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ГИДЦГ-ыг өргөтгөхөөр Булган сумаас 444364 га, Үенч сумаас 269196 га, Алтай сумаас 183689 га нийт 897249 га-аар өргөтгөх асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 100% саналаар дэмжиж УИХ-д өргөн барихаар болсон.	100
4.2.6	Орон сууцны дэргэд стандартын шаардлага хангасан хогийн пункер тавьж, хог ялган боловсруулах үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжинэ.	Хогийн менежментийн чиглэлээр орон сууцны хороолол болон зам дагуу 46,1 сая төгрөгийн өртөг бүхий хогийн савуудыг Бүргэтэй ХХК хийж гүйцэтгэлээ.	100
4.2.7	Хотын ногоон байгууламжийг 5 га-гаар нэмэгдүүлж зарим багт усан оргилуур бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулна.	Ховд хотын төвийн зам дагуу “А” бүсэд хамгаалалтын саад ногоон байгууламж хийсэн ба Жаргалан багт усан оргилуур бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн байгууллаа.	100
4.2.8	Утаа, тоосжилтыг бууруулах стратеги гаргана.	Аймгийн Засаг даргын “Агаарын бохирдлыг бууруулах тухай” 01 тоот албан даалгавар гаргаж, баг оврын 93 халаалтын зуухыг 2014 оны 10 дугаар сарын 1 гэхэд зогсоож, цахилгаан халаалт, төвлөрсөн дулааны станцад холбох тухай үүрэг чиглэл өгсний дагуу Жаргалант сумын ЗДТГ, Стандартчилал хэмжилзүйн газар, Газар хөдлөлийн станц цахилгаан халаалтын системд, Төрийн банк, Номин худалдааны төвүүд дулааны нэгдсэн сүлжээнд холбогдоод байна. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны салбар хороог байгуулан Ховд хотын агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулж, 2013 оны 12 дугаар сард багтааж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангаж байна.	90
4.2.9	“Ус” дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Хар нуур Ховд голын сав газрын зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Мөн шинээр Булган гол, Үенч, Бодончийн голыг хамгаалтад авахаар ажиллаж байна.	100
4.2.10	Аймгийн тохижилт үйлчилгээний орон нутгийн	Аймгийн тохижилт үйлчилгээний Эрч-Хүч орон нутгийн өмчит компани байгуулан тоног төхөөрөмжөөр ханган	100

өмчит компани байгуулна.	ажиллаж байна.	
--------------------------	----------------	--

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2013 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ, 2014 ОНЫ ЗОРИЛТЫН ТУХАЙ

2013.11.25

Ховд

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Төрийн удирдлага, эрхзүйн бодлого, Нийгмийн бодлого, Эдийн засаг, үйлдвэрлэл, худалдаа, дэд бүтэц, барилга, хот байгуулалт, газрын харилцааны бодлого, Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого гэсэн 4 бүлэг, 11 дэд бүлэг, 140 заалттайгаар боловсруулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг бүх сум, байгууллагын удирдлагуудад албан бичгээр хүргүүлэн хэрэгжүүлэхийг үүрэг чиглэл болгож ажиллалаа.

Төрийн удирдлага, эрхзүйн бодлогын хүрээнд 22 заалтыг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 9 заалт 100, 9 заалт 90, 2 заалт 70, 2 заалт 50, дунджаар 88.6 хувийн биелэлттэй,

Нийгмийн бодлогын хүрээнд 60 заалт хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 39 заалт 100, 5 заалт 90, 9 заалт 70, 2 заалт 50, 4 заалт 30 (Жаргалант сумын 1 дүгээр сурууль, Цаст-Алтай, Чандмань, Дөргөн, Үенч, Булган, сумдын сургуулиудын өргөтгөлийн барилгыг шинээр барина. Жаргалант суманд 150, Мөст суманд 100 хүүхдийн цэцэрлэг шинээр барина. Жаргалант суманд соёл, спортын цогцолбор, Үенч суманд урлаг спортын цогцолбор төв байгуулна. Манхан, Ховд сумын спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулна. Булган сумын нэгдсэн эмнэлэг, Зэрэг, Чандмань Мянгад сумын эрүүл мэндийн төвийг иж бүрэн гал тогооны цахилгаан хэрэгслээр хангана.), 1 заалт 10 (Мөст сумын сургуулийн дотуур байрны барилгыг шинээр

барьж, Жаргалант сумын дотуур байрны барилгыг засварлана.), дунджаар 86.8 хувийн биелэлттэй,

Эдийн засаг, үйлдвэрлэл, худалдаа, дэд бүтэц, барилга, хот байгуулалтын бодлогын хүрээнд 39 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 14 заалт 100, 11 заалт 90, 6 заалт 70, 6 заалт 50, 2 заалт 30 (Улаанбаатар хотод Ховд аймгийн төлөөлөгчийн газар байгуулж, төмс хүнсний ногоо хадгалах 1000 тонн хүртэл багтаамжтай зоорь байгуулах газрын болон хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ. Аймгийн брэнд бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо борлуулах цэгүүд байгуулна. Ард-Аюушийн талбайн шинэчлэлийн ажлыг дуусгаж, тохижуулна. Ховд хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн баталж, Монгол улсын жишиг “Ховд хот” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Цементийн үйлдвэр байгуулах асуудлаар судалгаа хийж барих ажлыг эхлүүлнэ.), дунджаар 81.3 хувийн биелэлттэй,

Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд 19 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 9 заалт 100, 6 заалт 90, 2 заалт 70, 1 заалт 50, 1 заалт 30 (Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж барина.), дунджаар 87.4 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт нийт дүнгээрээ 85.6 хувийн биелэлттэй хэрэгжжээ.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийг үндэслэн хэрэгжих боломж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон боловсрууллаа.

Үндсэн чиглэлийн төсөлд 4 бүлэг, 12 дэд бүлэг, 143 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн та бүхэнд танилцуулж байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ч.СҮРЭНЖАВ

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн талаар:

Төлөөлөгч нөхөд өө!

Ховд аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн талаар та бүхэнд товч танилцуулъя.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрийн мөнгөний бодлого, Монгол улсын 2014 оны төсөв, аймгийн 2014 оны төсвийн төсөл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон төр засгаас явуулж буй бодлоготой нягт уялдуулан аймгийн өмнө дэвшигдэж буй зорилтыг хангах, ард иргэдийн аж байдлыг сайжруулахад чиглүүлэн 4 бүлэг, 12 дэд бүлэг, 143 зорилт арга хэмжээг тусган хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулж та бүхэнд танилцуулж байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн зорилт нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг бүрэн хангахад чиглэгдэж байна.

2014 онд хэдийгээр улсын эдийн засгийн байдал сайнгүй, хөрөнгө оруулалтын хэмжээ бага байгаа боловч өөрсдийн нөөц бололцоог бүрэн ашиглан ажлын байрыг нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх зорилтыг хөдөө орон нутаг руу чиглүүлэхийг гол зорилгоо болгож байна.

Ирэх онд Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, дулааны 2 дугаар станцыг ашиглалтад оруулах, Галдан бошигт хааны мэндээлсний 370 жилийн ойг угтсан бүтээн байгуулалт, тохижилтын ажил зэрэг томоохон зорилтууд дэвшүүлэхийн зэрэгцээ төрийн үйлчилгээ, нийгмийн салбарын хөгжлийг хангах, эрчимжүүлэх зорилтуудыг дэвшүүлээд байна. Эдгээр зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлснээр аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

Эрхэм хүндэт төлөөлөгчид өө!

Та бүхэнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг танилцууллаа. Дээрх асуудлуудтай холбогдуулан үнэтэй санал бодлоо илэрхийлж, бодитой дүгнэлт өгөн, үндсэн чиглэлийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.